

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

Үндсэн зүйл

Компанийн засаглалын үндэсний зөвлөл түүний ажлын алба Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийнхээ хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран тодорхой ажлуудыг хийж ирлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны нэг нэгж болох компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албанаас 2014 оны үйл ажиллагааны төсөл, төсвийг гарган Хороонд танилцуулсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийн асуудлаар Улсын их хурлын дарга З.Энхболдод хандан албан бичиг хүргүүлсэн байна.

Зөвлөл түүний ажлын албанаас 2014 оны байдлаар нийт 60 албан бичиг боловсруулан бусад байгууллага, газар хэлтсүүд рүү явуулсан байна. Харин бусад байгууллага, газар хэлтсүүдээс нийт 54 албан бичиг ирсэн бөгөөд уг албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. Компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албаны ажилтнуудтай хийсэн үр дүнгийн гэрээ болон шинээр ажилд орсон хүмүүсийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан Тамгын газарт өглөө.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг хэд хэдэн удаа зохион байгуулахаар ажилласан бөгөөд сүүлийн хагас жилийн хурлыг 11 дүгээр сарын 27-ны өдөр 70 хувийн ирцтэйгээр зохион байгууллаа. Тус хуралд “Компанийн засаглалын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвийн хүрээнд зөвлөлийн гишүүд санал бодлоо солилцож, Компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албаны үйл ажиллагааны тайлан, Төрийн өмчийн хорооноос 2014 онд хийгдсэн судалгааны танилцуулга, хувьцаат компаниуд өөрөө өөрсдийнхөө засаглалыг үнэлэх асуулга, аргачлал болон бусад хийж гүйцэтгэх, арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэв.

“Компанийн засаглалын үндэсний тайлан-2013”-ийн үр дүнг дүгнэж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлсэнээр аливаа компанийн нээлттэй ил тод, хариуцлагатай байдал сайжран хөрөнгө оруулалт нэмэгдэж эдийн засаг эрчимтэй хөгжих таатай орчин бүрдэх тул Хорооны Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газарт судалгааны дүгнэлтийн дагуу хийх тодорхой ажлуудын саналуудыг нэгтгэн хүргүүллээ.

Зорилт 1. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлд тавигдсан дээрх зорилтын хүрээнд Монгол дахь Олон улсын санхүүгийн корпорацийн зөвлөхийн зөвлөмжийн дагуу

компанийн засаглалын кодексийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Олон улсын санхүүгийн корпораци, Глобал компанийн засаглалын форум болон салбарын судлаач, туршлагатай мэргэжлийн хүмүүсээс санал зөвлөмж авч тусган Санхүүгийн зохицуулах Хорооны 2014 оны 05-р сарын 07-ний өдрийн хурлын 162-р тогтоолоор “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн батлуулж Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудад мөрдөж ажиллуулах шийдвэрийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан өмнө нь стандарт болгон батлуулсан кодексийг Хорооны удирдлага, Олон улсын санхүүгийн корпорацийн санал зөвлөмжийн дагуу хүчингүй болгуулахаар Стандарт хэмжилзүйн газрын холбогдох хүмүүстэй ярилцан албан бичгийг явуулаад байгаа бөгөөд 2015 оны эхний сард уг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүний нэг нь кодексийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын үнэлгээний аргачлал боловсруулж үнэлгээг тогтоох үндсэн үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллаж байна. Ажлын хэсгээс Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн засаглалын кодексийн дагуу өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээний асуулга түүний аргачлалыг боловсруулан Хорооны даргын албан тоотоор тус үйл ажиллагааг хувьцаат компаниудын хүрээнд мөрдүүлж түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголын хөрөнгийн биржид үүрэг болголоо.

Түүнчлэн Монголын хөрөнгийн биржээс Монголын компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөхтэй холбогдуулан тунхаг бичгийг боловсруулан хамтран ажиллах талаар одоогийн “А” самбарт бүртгэлтэй нийт 20 хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт e-мэйл явуулж утсаар холбоо барьж ач холбогдлыг тайлбарлан таниулж тус бичгийн загварт санал авч ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд компанийн засаглалын үндэсний зөвлөл, Монголын хөрөнгийн бирж, топ 20 индексийг бүрдүүлэгч хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нар гурвалсан гарын үсэг зурж баталгаажуулан сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т нэгдэж хамтран ажиллах үйл ажиллагааг Монголын хөрөнгийн биржтэй хамтран 12 сарын 24-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Компанийн нийгмийн хариуцлага нь нийгэм, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний эрхийн асуудал түүний харилцан хамаарлыг бүхэлд нь авч үздэг бөгөөд энэ нь төр засаг, байгууллага, хувь хүн бүрийн хариуцлагын асуудал юм. Энэ нь компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шийдвэрлэх зохих нэг чухал асуудал бөгөөд үүний хүрээнд зөвлөлийн ажлаас албаны санаачилгаар Эдийн засаг хөгжлийн яамны дэргэд компанийн нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж Монгол улсын хэмжээнд компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн судалгаа, олон улсын

туршлага зэргийг судлан мэргэжлийн хүмүүсийн санал зөвлөмжийг тусган уг баримт бичгийн төслийг боловсруулан гаргалаа.

Баримт бичгийн зорилго нь компанийн нийгмийн хариуцлагын талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх түүнийг төрөөс хөхүүлэн дэмжих, урамшуулах, улмаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад тэдгээрийн оруулах хувь нэмрийг бодитойгоор нэмэгдүүлэхэд оршиж байна. Баримт бичигт төрийн өмчит компани, хувьцаат компанийн үйл ажиллагаанд компанийн нийгмийн хариуцлагыг нэвтрүүлэх; компанийн нийгмийн хариуцлагын ил тод байдал, тайлагналын тогтолцоог бий болгох; компанийн нийгмийн хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд шинжлэх ухаан, боловсрол, сургалт, судалгааны байгууллагын оролцоог бий болгон нэмэгдүүлэх; нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэхэд компанийн нийгмийн хариуцлагын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх; компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх орчинг боловсронгуй болгох гэсэн үндсэн 5 зорилтыг тодорхойлон заагаад байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэгч Монгол банкны хувьд арилжааны банкуудын засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Монгол банкны ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар “Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам”, “Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ыг тус тус шинэчлэн батлуулжээ.

Банкны зохистой засаглалын хэрэгжүүлэх журамд хувьцаа эзэмшигчдийн талаар: хувьцаа эзэмшигчид банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохыг хориглох, хувьцаа эзэмшигчид банкны үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан мэдээллийг зөвхөн төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан гаргуулан авах, банкны хувьцаа эзэмшигч (хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч), түүнтэй холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг банк болон зохицуулагч байгууллагад мэдээлэх; төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар: үйл ажиллагааны хэлбэр нь хурал, хурлын шийдвэр байх, төлөөлөн удирдах зөвлөл нь эрх үүргээ хэрэгжүүлэх үүднээс хороодыг байгуулж, хороод нь чиг үүргийн дагуу тухайн асуудлаар дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод чиг үүргийн дагуу банкны үйл ажиллагаанд хяналт тавих, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, түүнтэй холбогдох этгээдийн зээл нь чанаргүй ангилагдсан тохиолдолд тус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд саналын эрхтэйгээр оролцохыг хориглоно; төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний талаар: зөвхөн хувь нийлүүлэгчдийн хурлаас томилж байх, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх тохиолдолд үндэслэл, тайлбараа Монгол банкинд ирүүлж, зөвшилцөх; хараат бус гишүүн нь банкны хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчих тохиолдол бүрт Монгол банкинд мэдэгдэж байх үүрэгтэй байх, хувь нийлүүлэгчдийн хурлаас гадна Монгол банкинд ажлаа тайлагнадаг байх; ажиллах нөхцөл, ажлын хөлс, урамшууллын хэмжээний талаар: бусад гишүүдээс

дордуулахгүй байх; гүйцэтгэх удирдлагын талаар: гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно, аудит болон эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох; гүйцэтгэх удирдлагын үүргийн хувьд: банкны хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх үүднээс холбогдох журам, бодлогын баримт бичгийг боловсруулж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашиг хөндөгдсөн, хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд уг үүргийг биелүүлэхээс татгалзах, энэ талаар Монгол банкинд мэдэгдэх; эрсдэлийн удирдлага, дотоод хяналт: банк нь зохистой дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх, мэдлэг чадвартай, эрх мэдэлтэй, хангалттай боловсон хүчний нөөцтэй, хараат бус байдал, төлөөлөн удирдах зөвлөлтэй шууд харилцах эрхтэй байх, банкны эрсдэлийн ерөнхий түвшин, эрсдэлийн төрөл тус бүрээр тодорхойлж, дүн шинжилгээ хийж тухай бүр төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байх; төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь дотоод аудит, хөндлөнгийн аудит болон дотоод хяналтаар хийгдсэн ажлын үр дүнг ашиглах ёстой; тайлагнал, ил тод байдал: банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, бүтэц зохион байгуулалт, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан /тайлагналын стандарт/, банкны толгой болон салбар компаниуд, түүний үйл ажиллагаа, засаглалын талаар, банкны нийгмийн хариуцлагын талаар тайлагнах, холбоотой этгээдтэй холбоотой хэлцлийн талаарх мэдээлэл зэргийг ил тод мэдээлэх талаар тусгасан байна.

Дээрх журам, загвар батлагдсантай холбогдуулан Монгол банкны ерөнхийлөгч, сангийн сайд, санхүүгийн зохицуулах хорооны даргын 2010 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 434/133/167 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх” журамд дараах нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн байна.

Журмын 1.3 дахь заалт “Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл нь нэг ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна” гэсэн заалт дээр нэмж “Системийн нөлөө бүхий банк компанийн хэлбэрээс үл хамааран төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна” гэж, журмын 5.12 дахь заалт “Нэрсийн жагсаалтаас шаардлага хангасан болон Монгол банкнаас зөвшөөрсөн нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хорооноос төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулна” гэсэн заалтыг “Нэрсийн жагсаалтаас шаардлага хангасан болон Монгол банкнаас зөвшөөрсөн нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хорооноос хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулна” гэж, Журмын 6.1 дэх заалт “хараат бус гишүүний сонгуульт хугацаа дуусгавар болж, улиран сонгогдоогүй бол хараат бус гишүүнээс чөлөөлөгдөнө” гэсэн заалтыг “Хараат бус гишүүний сонгуульт хугацаа дуусгавар болсон, улиран сонгогдоогүй болон 6.2 дахь заалтаас үл

хамааран үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд холбогдох үндэслэл, тайлбарыг Монгол банкинд ирүүлж, зөвшөөрөл авна” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газраас компанийн засаглалыг компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх бодлогын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс хорооны 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 268 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаанд зайны хяналт тавих журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.

Тус журмын 2.5. дахь хэсгийн “...“Компанийн тухай” хуулийн 60.3-т гэж заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болсон тухай болон хурал зарлан хуралдуулах эрх нь хувьцаа эзэмшигч бүрт нээлттэй болсон тухай нийтэд зарлаж, харилцагч банкинд мэдээлнэ ...” гэснийг “... Компанийн тухай хуулийн 59.7-д заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ энэ хуулийн 59.4-т заасан хугацааны дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээлнэ ...” гэж, журмын 2.6. дахь хэсгийн “...“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 10.1.5-д зааснаар хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын шийдвэр, тэмдэглэлийг 6 дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлынхыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор хороонд ирүүлж байх ёстой...” гэснийг “... Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8.хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх...” гэж, журмын 2.7. дахь хэсгийн “... Компанийн тухай хуулийн 64.7-д хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэж болохгүй гэж заасан. Иймд хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан бол уг шийдвэрийг хүчингүй гэж үзэх үндэслэл болно...” гэснийг ... “ Компанийн тухай хуулийн 63.10-д Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудал ороогүй асуудлыг хэлэлцэхгүй, мөн хуулийн 63.11-д шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 66 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг компанийн дүрэмд зааж болно ...” гэж, журмын 3.1 дахь хэсгийн “... Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.1.3-т заасны дагуу хувьцаат компани нь хагас жилийн болон аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, хороонд ирүүлэх үүрэгтэй...” гэснийг “...20.1.6.хагас жилийн болон хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй. Хорооны тайланд холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу хяналт тавина...” гэж, журмын 5.1 дэх хэсгийн “... Монголын компанийн засаглалын кодекст заасан дараах 5 дотоод журмыг боловсруулан баталж, хорооноос тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэхийг хянана. 5.1.1. Хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах журам; 5.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам; 5.1.3. Мэдээллийн үйл ажиллагааны журам; 5.1.4. Дотоод хяналтын журам; 5.1.5. Ногдол ашгийн бодлого...” гэснийг “...6.1.13.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын

үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах ...” гэж тус тус өөрчилсөн байна.

Хорооны 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 15.1-д “Зохицуулалттай этгээд нь хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх журамтай байх ба дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлсон байна” гэж заасны дагуу компаниудад 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 3/1066 болон 2014 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 5/3266 дугаар албан бичгээр зохицуулалттай этгээдэд шинэчлэн тогтоогдсон хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа, холбогдох дүрэм, журмаа шинэчлэх талаар хүргүүлсэн.

Түүнчлэн “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны тухай журам”, “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-дыг Хороогоор шинээр батлуулж “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, санал өгөх эрх, мэдээлэл авах эрх, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг сайжруулах талаар тусгаад байна.

Монголын хөрөнгийн биржээс шинэчлэн баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д Монголын хөрөнгийн биржийн “А” ангилалд бүртгэгдэх компани нь компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, бусад ангиллын компаниуд нь дагаж мөрд, эсхүл тайлбарлах зарчмыг баримтлах талаар нэмэлт шалгуурыг тусгаж өгсөн бөгөөд бүртгэлтэй байх хугацаанд жил бүр засаглалын тайланг гаргаж байх, мэдээллийн ил тод нээлттэй байдлын зарчмыг дагаж мөрддөг байх зэрэг асуудлуудаар журамд нилээд дэлгэрэнгүй тусгаж өгч Монголын хөрөнгийн биржийн “Хяналт шалгалтын журам”-д үнэт цаас гаргагч компаниудын компанийн засаглалын хэрэгжилтийн байдлыг хянах талаар нэмэлт заалт оруулан батлуулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус журмын 7.2.4 дахь заалтад “Компанийн засаглалын зарчмуудын үйл ажиллагаандаа мөрдөж буй эсэх”-д хяналт тавих, мөн “Бүртгэлийн журам”-ын 12.1.6 заалтад “Дотоодод болон олон улсад зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх”, 13.1.5 дахь заалтад “Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн үнэт цаас гаргагчдын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилтын хүрээнд ханшинд нөлөөлөх мэдээллийн жагсаалт болон хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийн нэгдсэн жагсаалтыг гаргаж, мэдээллийн агуулга, хугацаа, тайлагнах арга, тайлангийн загвар зэргийг хамруулсан “Мэдээлэл түгээх заавар” гаргахаар ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 31.1 дэх хэсгийн “Бүх гишүүдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зарлан хуралдуулна”, 31.2 дахь хэсгийн “... хуралдуулах зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ” гэсэн заалтуудын дагуу нийт 138 ХЗХ-ны 94.9 хувь буюу 131 Хадгаламж зээлийн хоршоо бүх гишүүдийн хурлын материалыг Хороонд ирүүлснийг хянан, анхаарах асуудлаар зөвлөмж хүргүүлэн, хяналт тавьж ажилласан.

“Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-д даатгалын компаниуд 5-аас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, Хорооноос баталсан компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар тусгахаар төслийг боловсруулан батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна.

Төрийн өмчийн хорооноос боловсруулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журмыг нэмж сайжруулах зорилгоор зөвлөлтэй хамтран ажлын хэсгийг байгуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулан засгийн газрын хэрэг эрхлэх газар, төрийн өмчийн хороонд явуулсан. Төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодыг байгуулсан бөгөөд санхүүгийн зохицуулах хорооноос баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн дэд хороодын болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэх ажил хийгдэж дууссан ба төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ыг шинэчлэх ажил явагдаж байна.

Зорилт 2. Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага манлайлах

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад төрийн өмчийн хорооны даргын 2013 оны А/280 тоот албан даалгаврын хэрэгжилтийг тайлант онд үргэлжлүүлж байгаа бөгөөд эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын тулгуур зорилт болгон, түүнийг хэрэгжүүлэх үндэслэл болсон зайлшгүй шаардлага бүхий мэргэжлийн баг /Хууль эрх зүйн алба/-ыг гүйцэтгэх захирлын шууд харьяанд байгууллаа. Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны удирдлага менежментийг сайжруулах, үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах талаар төрийн өмчийн хорооноос удирдамжаар үүрэг өгч ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн болон компанийн үйл ажиллагааны талаар жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг шаардах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийнхээ болон хороодын хуралд оролцсон оролцоо, төлөөлөн удирдах зөвлөлийн хүрээнд хийсэн ажил болон үүргээ биелүүлж байгаа байдлын талаар дүгнэлт өгөх ба дүнг хувьцаа

эзэмшигчдийн хуралд тайлагнаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2013 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай шийдвэр гаргаж 10,5 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас 11,9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. 2014 оны тухайд 9,7 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төрийн өмчийн хороо нь өөрийн харьяа 94 төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, компани үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааг сангийн сайдын 2007 оны тушаалын дагуу төлөвлөгөө, тайланг нэгтгэхийн зэрэгцээ үйл ажиллагаанд нь ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж хяналт тавьж ирсэн байна.

Төрийн өмчийн хорооноос компанийн сайн засаглалын тухай олон нийтийн ойлголтыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа хийх, эрх зүйн орчинг сайжруулж, хууль сахиулах, хянах, зохицуулах чадавхыг бэхжүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, засаглалыг хөгжүүлэх хүрээнд олон нийтийн хэрэгслэлээр байнга мэдээллэх, компанийн засаглалын кодекс, компанийн засаглалын зарчмуудыг компани дээрээ бий болгох, таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тухай бүр зөвлөмжийг өгч ажилласан.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани нь иргэд, аж ахуй нэгжүүдийн цаг завьг хэмнэх, мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх үүднээс хэрэглэгч техникийн нөхцөлийн хүсэлтээ бөглөж өгөх, хүссэн техникийн нөхцөлийн шийдвэрлэлтийн явцыг интернэтээр хянах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд авлага барагдуулагч болон хэрэглэгчийн цахилгааны төлбөрийг газар дээр нь ухаалаг гар утас ашиглан хүлээн авах үйлчилгээг нэвтрүүллээ.

Төрийн өмчийн хорооны цахим хуудсанд сар бүр тогтмол хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчит компанийн танилцуулгыг нэгдсэн форматаар гаргах замаар үйл ажиллагаа, засаглалын нээлттэй байдлыг нийтэд танилцуулах, компанийн засаглалын суурь тавих, төрийн өмчийн хорооны компанийн засаглалд оруулах хувь нэмрийг олон нийтэд таниулах ажлуудыг зохион байгуулсан.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой 51 компани төлөөлөн удирдах зөвлөлтэй үүнээс 31 компани хуулийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээ сонгосон. Нийт 51 төлөөлөн удирдах зөвлөлд 425 гишүүн ажиллаж байгаа бөгөөд үүнээс 102 нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Монгол улсын засгийн газрын 2013 оны 16 дугаар тэмдэглэлийг үндэслэн төрийн өмчийн удирдлагын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, цалингийн дээд хэмжээг бүрэн шинэчлэн тогтоосон.

Төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит компаниудын 2013 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, гүйцэтгэх захирал, захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж, 2014 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж гаргасан.

Авто замын салбарын төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд авто замын засвар арчлалтын талаарх танин мэдэхүйн болон практик сургалтыг 2014 оны 5 дугаар сарын 14-нөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтаар автозамын ач холбогдол, бүс нутгийн болон Монгол улсын автозамын сүлжээ, олон улсын гэрээ хэлэлцээр зэрэг автозамын тухай ерөнхий ойлголт, авто замын тухай хууль, төрөөс баримтлах бодлогын баримт бичигт эрх зүйн зохицуулалтыг хэрхэн тусгасан, авто зам засвар арчлалтын компаниудын үүрэг ролийн тухай авто замын эрх зүйн зохицуулалтын тухай сургалтыг Авто замын салбарын төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дунд амжилттай зохион байгуулсан.

Зорилт 3. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх компани, аж ахуйн нэгжийн удирдлага менежментийг сайжруулах

Ажлын албанаас 2014 онд хийх судалгаа түүнийг үндэслэн боловсруулах үндэсний тайлангийн чиглэлийг гаргасан. Тус судалгааг үндсэн хоёр чиглэл буюу 2013 онд хийсэн компанийн засаглалын судалгаа түүний зөвлөмжийн хэрэгжилт ба гадаадад хувьцаа гаргасан компаниуд болон уул уурхайн компаниудын засаглалын хүрээнд хийхээр төлөвлөөд байна. Энэхүү ажлын хүрээнд Уул уурхайн яамны бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Отгочулуу, Ашигт малтмалын газрын дэд дарга Д.Үүрийнтуяа нартай уулзаж дээрх судалгаа, тайланг боловсруулах ажлын хэсэгт тус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хамтран ажиллахаар тохиролцсон. Судалгаа, тайланг боловсруулах төлөвлөгөө, гэрээний төсөл, төсвийг боловсруулан хорооны дарга, ажлын албаны даргад танилцуулан судалгааг хийх 8 судлаачидтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Дээрхи судалгааны хүрээнд компанийн засаглалын үнэлгээний судалгааны асуудлыг дагуу нийт 22 хувьцаат компани, 17 даатгалын компани, 20 банк бус санхүүгийн байгууллага болон 21 хадгаламж зээлийн хоршоодын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал эсвэл хувь нийлүүлэгчээс асуулга авах ажлын зохион байгуулж зарим судлаачдад хүргүүлж ажиллалаа. Түүнчлэн судлаачдыг шаардлагатай мэдээллээр хангуулах ажлыг зохион байгуулж судалгаанд холбогдох төрийн байгууллага, агентлаг, төрийн бус байгууллагууд руу албан тоотыг хүргүүлэн, тэдгээрийн үйл ажиллагааг хооронд нь холбох зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулж ирлээ. Судлаачдын ирүүлсэн тайланг үндэслэн компанийн үндэсний тайланг боловсруулах ажлыг зохион байгуулж ажиллахын сацуу түүнийг хэвлүүлэх эдгээр бүх үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх МОН004 төслөөр санхүүжүүлэх ажлыг ярилцан шийдвэрлээд ажиллаж байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас Монгол улсад компанийн нийгмийн хариуцлагын хөгжлийг татварын бодлогоор дэмжих боломж арга зам" судалгааг Оюу-Толгой, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудтай хамтран хийлээ. Компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн санаачлага, оролцоо, санхүүжилтийг

урамшуулах татварын тогтолцоог бий болгож, нийгэмд хандсан сайн дурын үйл ажиллагааг дэмжих явдал чухал ач холбогдолтой болохыг олон улсын туршлага харуулж байгааг уг судалгаагаар нотлон харуулсан байна. Компанийн нийгэм хариуцлагыг идвэхжүүлэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тухайн байгууллагын зардлыг нэмэгдүүлэх явдал үүсэж байгаа бөгөөд энэ нь нэг талаар татварын хөнгөлөлт, урамшууллын хүчин зүйл нөлөөлөөгүй тохиолдолд компанийн нийгмийн хариуцлагыг сайн дурын үүднээс хэрэгжүүлэх сонирхлыг бууруулж байдаг байна. Компанийн нийгмийн хариуцлагын хөгжлийг татварын механизмаар дэмжихдээ юуны өмнө нийгмийн хариуцлагын хүрээнд явуулах үйл ажиллагааны төрлийг хуулиар тогтоох шаардлага урган гарна. Нийгмийн хариуцлагын хүрээнд 1) татвар ногдох орлогоос хасаж тооцох, 2) тооцогдсон татвараас зарцуулсан зардлын тодорхой хувийг эсвэл бүхэлд нь албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх боломжтой. Дээрх хоёр зохицуулалтын аль ч хувилбарыг бий болгосон татвараас чөлөөлөгдөх дээд хязгаарыг тогтоож өгөх шаардлагатай байгааг судалгаа харуулжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газраас хорооны 2014 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн тоот албан бичгээр компанийн тухай хуулийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагатай талаарх сануулгыг хүргүүлжээ. Үнэт цаасны газраас 23 зохицуулалттай этгээдэд газар дээрх шалгалт хийсэн бөгөөд уг шалгалтын явцад холбогдох журмын шаардлагын дагуу дотоод хяналтын орон тооны ажилтантай эсэх талаар шалгасан байна.

Монгол улсын компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-аар хувьцаат компаниудад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийн байдал Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалагддаг, аж ахуйн үйл ажиллагаа нь явагдаж буй 185 хувьцаат компанийн хувьд дээрх судалгаа дараах байдалтай байна

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо	Компанийн дүрмээ шинэчлэн баталсан компанийн тоо	ТҮЗ-ийн хараат бус гишүүдийг сонгосон компанийн тоо
	142 ХК /76.7%/	179 ХК /96.7%/	150 ХК /81.1%/	166 ХК /89.7%/

Үнэт цаасны газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2014 оны 3 дугаар улирлын байдлаар тус хорооноос үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн 1, хөрөнгө оруулалтын менежментийн 2, кастодианы 2 компанид тусгай зөвшөөрөл олгоход, 5 зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг өөрчлөхөд холбогдох журмын 2.1.4 дэх заалт болон 13 дугаар зүйлийг удирдлага болгон зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал мэргэжилтнүүдийг тохиромжтой этгээд эсэхийг тогтоож ажилласан.


2013 оны компанийн засаглалын үндэсний тайлангийн зөвлөмжийн дагуу албаны зүгээс хорооны бусад газруудад чиглэл бүрт зориулсан зөвлөмжийг боловсруулан хүргэсэн. Энэхүү ажлын хүрээнд даатгалын газраас даатгалын салбарт компанийн засаглалыг нэвтрүүлэн тухайн компаниудад зориулсан компанийн засаглалын өөрөө өөрийгөө үнэлэх аргачлалыг боловсруулан мөрдүүлэх, түүнчлэн Хорооны Даатгалын газар Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс 2012-2013 онд хийсэн засаглалыг сайжруулах судалгааны ажлыг хэрэгжүүлж, АНУ болон Даатгалын хороодын үндэсний холбооны /NAIC/ компанийн засаглалын бодлого, дотоод хяналтын асуудалтай холбогдсон судалгааг 17 компанийг хамруулан хийж байна. Даатгалын газраас дээрх судалгааг хийж, дотоод хяналтын орчинг сайжруулснаар компанийн сайн засаглалыг төлөвшүүлэхийг зорьж байгаа ч өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан тэргүүн ээлжид дотоодын даатгалын зах зээлд тохирох засаглалын хөтөлбөрийг боловсруулах нь чухал гэж үзэж байна. Даатгалын газрын ердийн даатгалын хэлтсийн хяналтад байдаг 16 компанид газар дээрх шалгалтаар орохдоо компанийн засаглалыг хэрхэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа тусгаж байгаа талаарх шалгалтыг явуулж “Газар дээрх шалгалтын тайлан”-нд тусган, тайлагнаж эхлээд байна.

Бичил санхүүгийн газраас итгэлцлийн үйл ажиллагаа эрхэлж буй 21 банк бус санхүүгийн байгууллага, топ хадгаламж зээлийн хоршоо /300 сая төгрөгөөс дээш активтай 26 хадгаламж зээлийн хоршоо/-дын 2013 оны санхүүгийн тайлангийн шинжилгээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээллийг нэгтгэж авав. 2014 онд зохион байгуулах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран зохион байгуулах "2014 онд олон нийтэд болон зохицуулалтын байгууллагуудад зориулсан сургалт, сурталчилгааны төлөвлөгөө"-г боловсруулж, Ажлын албаны даргын 2014 оны 57 тоот тушаалаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу Банк бус санхүүгийн байгууллагуудын удирдах ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ба Компанийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын дагуу төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит компаниудын дүрмийг компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчилж, улсын бүртгэлд бүртгүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг хууль болон журмын дагуу сонгох асуудлыг жигдрүүлэн ажиллаж байна.

2014 оны 09-р сарын 01-ний өдрийн Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын 132 дугаар тушаалаар бүртгэлтэй хувьцаат компаниудын компанийн засаглалыг сайжруулах, төлөвшүүлэх компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангуулахад чиглэн ажиллах компанийн засаглалыг хариуцсан мэргэжилтнүүдийг томилон ажиллуулж байна.

Монголын хөрөнгийн биржийн журам, заавар гэрээнд тусгагдсан компанийн засаглалтай холбоотой хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажиллаж байна. Үүнд: Компанийн засаглалын үндсэн зарчмуудын нэг болох мэдээллийн ил тод байдлын зарчим, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах, төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагыг тодорхойлох гэх мэт асуудлуудыг багтаасан. Хувьцаат компаниудад хуулиар хүлээсэн тогтмол хэрэгжүүлэх ажиллагаа буюу үүргээ биелүүлэн ажиллахыг

мэдэгдэж бүх хувьцаат компаниудын удирдлага нарт 2014 онд 3 удаа албан тоот хүргүүлж, тогтмол шаардлага тавьж ажилласны үндсэн дээр 2014 оны 12-р сарын 10-ны байдлаар 179 хувьцаат компанийн хувь эзэмшигчдийн хурал хуралдуулахаар зарласан ба хурлын материал ирүүлсэн 148, 91 хувьцаат компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрээ, 276 хувьцаат компани санхүүгийн тайлангаа тус тус ирүүлээд байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан байдлыг өнгөрсөн онуудтай харьцуулсан байдлаар харуулбал:



УИХ хурлын гишүүний зүгээс хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тодорхой санал зөвлөмж ирсний дагуу компанийн тухай хууль болон холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах ажиллагааг идэвхтэй авч хэрэгжүүлсний үр дүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн ээлжит хурлыг цаг тухайд нь хуралдуулах явдал эрчимтэй явагдаж 2013 онд энэ үзүүлэлт нэлээд хэмжээгээр нэмэгдсэн байна. Мөн ногдол ашиг тараах ажиллагаа ч мөн сайжирсан бөгөөд үүнийг дараах байдлаар графикаар үзүүлж байна.



Харин 2013 оны хувьд нэлээд олон буюу 81 компани үйл ажиллагааны хэлбэрээ өөрчлөх үйл ажиллагаа идэвхтэй явагдаж эдгээр компанийн дотор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг компаниуд /Алтан тариа, Монгол эм импекс, Тулга хэрэглээ, / орсон нь 2014 онд хурлаа хийсэн болон ногдол ашиг тараасан компаниудын тоо буурахад нөлөөлөх нэг гол хүчин зүйл болсон гэж үзэж байна.

Компанийн засаглалын ил тод нээлттэй байдлыг бий болгох мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд “Эх орон” телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд долоо хоног бүр компанийн засаглалын талаар олон нийтэд танин мэдэхүйн цуврал мэдээлэл хүргэх асуудлыг шийдвэрлэх боломжийг олгох юм. Энэхүү ажлын хүрээнд бэлтгэн гаргах нэвтрүүлгийн төлөвлөгөөний төсөл, нэвтрүүлгийн зохиол, агуулгыг боловсруулан тус байгууллагад хүргүүлээд байна. Түүнчлэн хорооны цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шуурхай нийтлэн иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа болон засаглалтай холбоотой бусад мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор олон нийтийн цахим хуудас twitter.com, facebook.com сайтуудад өөрийн байгууллагын хаягийг нээн мэдээлэл түгээж эхэлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд компанийн засаглалын үндэсний зөвлөлийн зүгээс компанийн засаглалын портал сайттай болох бэлтгэл ажлууд хийгдэн сайтын загвар хийсэн байдлын талаар Зөвлөл түүний ажлын алба болон хорооны гишүүдэд танилцуулан ажиллуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын компанийн засаглалыг сайжруулах, төлөвшүүлэх, компанийн засаглалын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор өөрийн вэб сайтад “компанийн засаглал” гэсэн цэсийг шинээр бий болгохоор холбогдох бэлтгэл ажлыг бүрэн хийгээд байна. Түүнчлэн хувьцаат компаниуд санхүүгийн тайлан болон бусад нийтэд мэдээлэхээр хууль тогтоомж, дүрэм журамд заасан мэдээллүүдээ ирүүлсэн байдалд улирал тутам үнэлгээ хийх болон хууль, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, мэдээлэл судалгааг хөрөнгийн биржийн вэб сайтад байршуулах ажил байнга хийгдэж байна. Монголын хөрөнгийн биржийн “Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-ын дагуу компаниудад шаардлага хүргүүлж тэдгээрээс ирүүлсэн мэдээллийн дагуу нийтдээ 986 мэдээллийг өөрчлөн шинэчилж хөрөнгө оруулагчдад мэдээлж ажилласан байна.

Vip76.mn сайттай хамтран “Компанийн засаглалыг хөгжүүлэх нь” онлайн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 17 эксперт оролцсон бөгөөд компанийн засаглалыг хөгжүүлэх талаар санал бодлоо илэрхийлсэн тэдний ярилцлагыг нэгтгэн сэтгүүл болгон хэвлэсэн. Сэтгүүлийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд захирлуудад тараасан. Мөн компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албанаас тус сэтгүүлтэй хамтран ажиллаж VIP76-д компанийн засаглалын булан ажиллуулж 2014 оны №3 дугаарт компанийн засаглалын ил тод байдал, тайлагналын талаар мэдээлэл нийтлэл гаргасан. Энд мэдээллийг ил тод болгосны ач холбогдол, давуу талуудын талаар мөн ямар мэдээллүүдийг ил тод нээлттэй болгох асуудлыг онолын хувьд дурьдаад мөн энэ чиглэлээр мэргэжлийн оролцогч салбарын эксперт, шилдэг төлөөллүүдийн санал зөвлөмж, сайн туршлагыг олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтын байгууллага болон иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа мэдээллийг хүргэх зорилгоор Монголын үндэсний олон

нийтийн радио телевиз, 25-р суваг, Өдрийн сонин, Өнөөдөр сонин гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж байна.

Зорилт 4. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх

Албанаас мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран ажиллах гэрээний хүрээнд тодорхой ажлыг хийж гүйцэтгэж ирсэн бөгөөд Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуультай судалгааны ажил, зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллахаар уулзалт зохион байгуулж хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан санамж бичиг байгуулан ажиллаж эхэллээ. Компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банк, Жайка, Олон улсын санхүүгийн корпораци, Германий олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагуудтай уулзалтуудыг зохион байгуулж тэдгээрийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хамтран ажиллах боломж бололцоо байгаа эсэх талаар ярилцсан. Дэлхийн банкны хүрээнд компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын хууль эрх зүй, стандартын хэрэгжилтийн хүрээнд хийгдэх судалгааг хамтран хийх, шаардлагатай дүрэм, журмын боловсруулах, мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлын хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх зэргээр хамтран ажиллахаар эхний байдлаар ярилцаж хэлэлцээд ажиллаж байна. Мөн Олон улсын санхүүгийн корпорацийн азийн бүс нутгийг хариуцсан ажилтантай уулзаж тус байгууллагын хүрээнд хэрэгжүүлж буй компанийн засаглалын төслийн үр дүн гарч буй эерэг талууд болон цаашид түүний үр дүнг эрчимжүүлэхэд төслийг ач холбогдлыг тэмдэглэн цаашид хийх арга хэмжээний талаар санал бодлоо солилцлоо.

Тайлант хугацаанд компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд 2014 оны 3 дугаар сард Чингис хаан зочид буудалд зохион байгуулагдсан “Компанийн засаглал ба эрх зүйн зохицуулалт” семинарын үеэр 1 удаагийн хэлэлцүүлгийг явуулж 80 гаруй хувьцаат компанийн оролцогчдоос санал авч тусгаснаас гадна Хорооны сайтад кодексийг байршуулан санал авах ажлын зохион байгуулсан.

2014 оны 5 дугаар сард “Эрнст Янг” олон улсын аудитын байгууллагатай хамтран хувьцаат компани, төрийн өмчит хувьцаат компаниудад зориулсан Компанийн засаглал семинарыг зохион байгууллаа. Уг семинарт гадаадын мэргэжлийн өндөр туршлага бүхий илтгэгчид оролцож хувьцаат компани, төрийн өмчит хувьцаат компанийн засаглалын олон улсын туршлага, зайлшгүй шаардлага, цаашдын чиг хандлагын талаар илтгэл тавьж нийт 100 гаруй компани, байгууллага оролцлоо.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас компанийн нийгмийн хариуцлагын Азийн дээд хэмжээний уулзалт “CSR Asia Summit 2014” Хонг Конг-т 9 сарын 15,16,17-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ба үүнд 4 компанийн 4 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцсон бөгөөд цаашид CSR Asia-аас зохион байгуулж буй сургалтуудад хөнгөлттэйгээр суралцахаар болсон 9 сарын сарын 25-нд Дэлхийн зөн олон улсын

байгууллагатай хамтран “Компанийн нийгмийн хариуцлага-Хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг сургалтыг хамтран зохион байгууллаа.

Төрийн өмчийн хорооноос компанийн тухай хуулийн дагуу төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар сертификатжуулах ажлыг хийж дуусгасан бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан компанийн засаглалын үнэлгээний арга /Компанийн засаглалын үнэлгээний загвар, АНУ-ын хөгжлийн агентлаг, Бизнесийг дэмжих санаачилга/, компанийн засаглалын сертификатын сургалт/ Компанийн засаглалын институт, удирдлагын академи, компанийн засаглал ба Аудитын тогтолцоо /Санхүүгийн Зохицуулах Хороо, Нягтлан бодох бүртгэлийн институт/, Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт ба Компанийн Засаглалын кодекс /Улаанбаатар цахилгаан түгээх станц, Дарханы төмөрлөгийн үйлдвэр/, Бизнес төлөвлөлт /Монгол улсын их сургуулийн Бизнес төв, Японы хөгжлийн төв, Удирдлагын академи/, Авилгын эсрэг хуулийн сургалт Авилгатай тэмцэх газар, Эрчим хүчний байгууллага, төрийн өмчийн компаниудын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад санхүүгийн шинжилгээ хийх аргачлал болон худалдан авах ажиллагааны аргачлал сэдвээр, компаниудын захирлууд, төрийн өмчийн хорооны ажилчид/, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, гүйцэтгэх захирлуудад Хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх зааварчилгаа өгөх, авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалтыг Авилгатай тэмцэх газар болон “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудыг Австри, Герман улсуудад зохион байгуулагдсан менежментийн арга барилыг сайжруулах болон шинэ техник, технологиор баригдсан дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний станц, Автозамыг үзэж танилцах, Германы “51етепз” компанийн уулзалт, семинарт оролцуулсан.

Компанийн засаглалын хөгжлийн төв нь Олон улсын санхүүгийн корпораци, Компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албатай хамтран компанийн засаглалын чуулганыг 7 дахь удаагаа 2014 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Кемпински зочид буудалд зохион байгуулж нийт 85 хүн оролцсон байна. Энэ удаагийн чуулганд зохицуулагч байгууллага, арилжааны банк, бүртгэлтэй компанийн удирдлага, олон улсын санхүүгийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, компанийн засаглалын идэвхтэн сонирхогчид оролцож, “Сайн засаглалтай байх нь банканд яагаад чухал вэ, бүртгэлтэй компанид засаглалыг хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд болж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Чуулга уулзалтын зорилго Монголын санхүүгийн манлайлагчид, шийдвэр гаргагчид, олон улсын мэргэжилтнүүдийг хамтран Компанийн засаглалын 7 дахь удаагийн чуулганаар уулзуулж санхүүгийн байгууллага болон бүртгэлтэй компанийн засаглалын асуудлаар хэлэлцүүлэхэд оршиж байсан. Шинэчлэн батлагдсан компанийн засаглалын кодекс, Монгол банкны холбогдох зохицуулалт ч энд мөн хамаарсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Даажамба, Монгол банкны хяналт шалгалтын газрын дарга Ганбат, Олон улсын санхүүгийн корпорацийн компанийн засаглалын ахлах зөвлөх Филип Армстронг нар илтгэл тавилаа.

Сүүлийн жилүүдэд компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг гүйцэтгэж ирлээ. Үүний нэг ажил болох Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форум нь орчин үеийн Нийгмийн хариуцлагын салбар дахь тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулан илтгэл, танилцуулга, семинар болон хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг. Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, Түүхий эдийн иж бүрэн санаачлаг хөтөлбөр хамтран 2014 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдөр Туушин зочид буудалд Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форумыг зохион байгууллаа.

Форумаар компанийн засаглал – Хувийн хэвшлийн санал санаачлага ба Засгийн газрын бодлогоор тэдгээрийг хэрхэн дэмжих вэ? Компанийн нийгмийн хариуцлагын олон тал – Ногоон хөгжил, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний эрх нь компанийн нийгмийн хариуцлагын бүрэлдэхүүн хэсгүүд болох нь; компанийн засаглал ба ил тод байдал – Монгол улсад олон улсын тэргүүн туршлагыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?; Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний бодлогын төсөл, хэрэгжилтэд өгөх санал зөвлөмж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг сэдвүүдийг анх удаа онцлон, гадны судлаачдын илтгэлүүдтэй танилцан, үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг өрнүүлээ.

Форумын нээлтийг Монгол улсын их хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар, үндсэн илтгэлийг Транспэрэнси Интернэшнлийн ази, номхон далайн бүсийн захирал Др. Срирак Плипат танилцуулсан ба гадаад, дотоодын олон судлаачид, бизнес эрхлэгчид илтгэл, танилцуулга тавьж хэлэлцүүлэг өрнүүлэв. Тус форумд төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, их сургууль, хэвлэл мэдээллийн нийт 60 гаруй байгууллагын нийт 160 гаруй төлөөлөл оролцов.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлаг хөтөлбөр нь үйл ажиллагааныхаа хүрээнд 2011 оноос Компанийн нийгмийн хариуцлагын талаарх цогц ойлголтыг оролцогч талуудад танилцуулах, чадавхжуулах зорилгоор компанийн нийгмийн хариуцлагын үндэсний форум, танилцах аялал, бага хурал, дугуй ширээний уулзалт, сургалт семинарыг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран шат дараатайгаар амжилттай зохион байгуулсаар ирсэн.

Үүний нэг нь 2012 оноос тогтмол зохион байгуулж буй “Компанийн нийгмийн хариуцлага ба тогтвортой хөгжил” дугуй ширээний уулзалт бөгөөд уг энэхүү уулзалтад Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудын төлөөлөл оролцож, компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр санал бодлоо солилцон, хамтран ажилладаг. “Тинк танк” (Think tank) стратегийг баримталдаг тус уулзалтын үйл ажиллагаа нь улс төрөөс ангид, гагцхүү компаниудад чиглэсэн бөгөөд бизнесийн салбарын туршлага дээр суурилсан “Тэргүүн туршлагын загвар”-ыг боловсруулахаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар уулзалтад идэвхтэй оролцогч 25 уул уурхайн компанийн төлөөлөл Уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийн зөвлөл мэргэжлийн төрийн бус байгууллагыг байгуулахаар шийдвэрлэн алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хөгжүүлэхийг зорин ажиллаж байна.

Түүнчлэн Хүний эрхийн үндэсний комиссийн нийт 25 ажилтан нарт зөвлөлийн ажлын албанаас Олон улсын Германий хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлаг хөтөлбөртэй хамтран хүний эрхийн асуудал компанийн нийгмийн хариуцлагын нэг хэсэг болох нь сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахыг ажлыг амжилттай зохион байгууллаа. Мөн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлаг хөтөлбөрөөс Багануур хувьцаат компанийг компанийн нийгмийн хариуцлагатай жишиг компани болгох зорилгоор гадны болон дотоодын экспертүүдээс бүрдсэн ажлыг хэсгийг байгуулан зөвлөгөө өгч ажилласнаар тус компани өөрийн компанийн нийгмийн хариуцлагыг тодорхойлж ерөнхий стратегитайгаа уялдуулан түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Цаашлаад Эрдэнэс Монгол холдинг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах түүнийг боловсронгуй болгоход зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна.


Монголын банкны холбоо, Монгол банк, Нидерландын хөгжлийн банк (FMO) болон Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-аас хамтран зохион байгуулж буй “Холбоотой этгээдэд зээл олгох болон хувьцаа эзэмшигчдийн бусад ашиг сонирхлын зөрчил” сэдэв бүхий “Компанийн засаглалын өндөр түвшний хэлэлцүүлэг 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Бэст Вэстэрн Примьер Туушин Зочид Буудлын Соёмбо хурлын танхимд зохион байгуулагдав. Хэлэлцүүлгийн эхний хэсэгт компанийн засаглалын асуудлаар мэргэшсэн зөвлөхүүд олон улсын шилдэг туршлагаадаас хуваалцах бөгөөд хэлэлцүүлгийн 2 дахь хэсгийн үеэр Монголын банк санхүүгийн салбарын төлөөлөл болох Монгол банкны хянан шалгах газрын захирал Д.Ганбат, МБХ-ны ерөнхийлөгч М.Болд, Хаан банкны гүйцэтгэх захирал Норихико Като, Ариг банкны гүйцэтгэх захирал Д.Төмөрхүү, Компанийн засаглалын хөгжлийн төвийн удирдах зөвлөлийн гишүүн Э.Оюунбилэг болон Пи Давью Си-н аудит хариуцсан захирал Желена Песис нар сонирхолтой яриа өрнүүлэв.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тахимаас 2014 оны 10 сарын 30-нд компанийн хуулийн зөвлөхүүдийн үйл ажиллагааг сайжруулах, үүрэг хариуцлагыг тодорхой болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн “Хуулийн зөвлөхүүдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. 2014 оны 10 сард “Глобаль хүний нөөц форум”-г Хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан байна. Энэхүү форумгаар байгууллагын хүний нөөцийн бодлого ямар байх талаарх асуудлыг хэлэлцэж, цаашид бодит үр дүн гаргах хүртэл тодорхой зорилт болгох ажлыг эхлүүллээ. 9 сарын сарын 25-нд Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Компанийн нийгмийн хариуцлага хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг сургалтыг хамтран зохион байгууллаа. Азийн сан, Авилгатай тэмцэх газар, Америк нэгдсэн улсын олон улсын хөгжлийн агентлаг, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Улсын их хурал дахь Авилгын эсрэг парламентчдын албан бус бүлэгтэй хамтран “Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа” уриан дор “Авилгын эсрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх” үндэсний чуулганыг 2014 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгууллаа.


Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй МОН-9152 төслийн хүрээнд 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хадгаламж зээлийн хоршоодын сургагч багш нарт зориулан хадгаламж зээлийн хоршооны эрх зүйн зохицуулалтын чиглэлээр сургалтыг зохион

байгуулсан. Мөн тус төслийн хүрээнд хөдгөлөмж зээлийн хоршооны эрх зүйн орчин, төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон салбарын ач холбогдлын талаар сурталчлах ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр Хорооны Хадгаламж зээлийн хоршооны холбооны дарга Б.Пүрэв, Хадгаламж зээлийн хоршоодыг төлөөлж "Хас баян өлзийт" хадгаламж зээлийн хоршооны гүйцэтгэх захирал н.Давхарбаяр нарын оролцсон ярилцлагыг зохион байгуулсан байна. Мөн хадгаламж зээлийн хоршооны мөн чанар, ач холбогдол, агуулга, өнөөгийн байдлын талаар ТВ1 телевизэд шууд ярилцлага, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн цагийн хүрд хөтөлбөрийн зочны цагт ярилцлага, санхүүгийн лавлах мэдээ сонинд ярилцлага тус тус өгч, Монголын хадгаламж зээлийн хоршооны үндэсний хорооноос зохион байгуулсан “Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний анхдугаар форум”-д илтгэл тавьсан.

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 11 сургалтын байгууллагууд компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч сургалтын байгууллагууд 2010 оноос тус гэрчилгээ олгох сургалт явуулж эхлэн нийт 1900 гаруй хүн компанийн засаглалын гэрчилгээ аваад байна. 2014 оны байдлаар нийт 39 удаагийн сургалт зохион байгуулж 640 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулж гэрчилгээ олгосон байна. Нийт гэрчилгээ авсан иргэдийг 2010 оноос хойш графикаар харуулбал :



Эдгээр сургалтад хамрагдсан иргэдийн албан байгууллагын хэлбэрээр нь авч үзвэл:



Хорооны үйл ажиллагааны стратегийн баримт бичигт Хороог компанийн засаглалын үлгэр жишээ байгууллага болгох талаар заасан байдаг. Албаны санаачилгаар Санхүүгийн зохицуулах хорооны засаглал, түүний чадавхыг сайжруулах зорилгоор Хорооны нийт ажилтан албан хаагчдыг компанийн засаглалын сургалтад хамруулах ажлыг Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлаг хөтөлбөрийн санхүүжилтийн дор Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 2014 оны 2, 3 дугаар саруудад 3 удаагийн 3 өдрийн сургалт зохион байгуулж нийт 97 ажилтан албан хаагчид хамрагдаж аливаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллах боломжийг олгох компанийн засаглалын сертификатыг олгоод байна.

Компанийн засаглалын кодекс шинэчлэгдэн батлагдаж, Монголын хөрөнгийн биржийн “А” самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниуд энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллах ба бусад хувьцаат компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаараа тайлбарлаж ажиллахыг үүрэг болгосонтой холбогдуулан компаниудын удирдлагуудыг хамруулан 300 хүний сургалтыг 10 удаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 8 удаагийн сургалтыг Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр 2014 оны 6 сараас 10 сарын хооронд амжилттай зохион байгууллаа. Сургалтад оролцсон байдлыг харуулбал:



Сургалтад нийт 94 компанийн 167 хүн оролцсоноос 63 хувьцаат компанийн 117, Хөдөө аж ахуйн биржийн 15, 10 брокер дилерийн компанийн 19, 10 даатгалын компанийн 16 хүн тус тус хамрагдсан байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажлын хүрээнд өнгөрсөн хугацаанд компанийн засаглалын 68 сургагч багш, нийгмийн хариуцлагын чиглэлээр 30 сургагч багшийг бэлтгэн гаргасан Монгол улсын хэмжээнд нийт 98 сургагч багш нарыг бэлтгэн гаргасан байна. Тайлант хугацаанд сургагч багш нарын мэдлэг, заах арга барил түүний ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ахисан түвшний 2 төрлийн сургалтыг Олон улсын санхүүгийн корпораци, Германы олон улсын хамтын нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран аудитын чиглэлээр ахисан түвшний сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар тохиролцож сургалтын хөтөлбөрийн төсөлд санал өгч нийт 28 компанийн засаглалын сургагч багш нарыг тус сургалтад хамруулан ажилласан байна. Германы олон улсын хамтын нийгэмлэгээс компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр 2 удаагийн ахисан түвшний сургагч багшийн сургалт зохион байгуулсан байна. ISO26000 стандартыг хэрхэн таниулан заах талаар 14 нийт сургагч, сургалтыг хэрхэн явуулах аргачлал сэдвээр нийт 20 сургагч багшийг хамруулсан ахисан түвшний сургалтыг зохион байгуулсан.

Олон Улсын Санхүүгийн корпорацитай хамтран компанийн засаглалын судлаачдад зориулсан олон улсын санхүүгийн корпорацийн компанийн засаглалын үнэлгээний аргачлал ба ТОП20 хувьцаат компаниудын хүрээнд хийсэн компанийн засаглалын үнэлгээний аргачлал сэдвээр нийт 10 судлаачдыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа.

Компанийн засаглалын хөгжлийн төв нь Азийн хөгжлийн банктай хамтран банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, удирдах ажилтнуудад зориулсан компанийн засаглалын сургалт зохион байгуулсан.

Мэргэшсэн нягтлан боллогч, аудиторуудаар дамжуулан компанийн засаглалыг сайжруулах, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх эрүүл бүтцийг бий болгох зорилгын хүрээнд 3 түвшинд хөтөлбөрийг уялдуулан ажиллаж байна.

- Мэргэшсэн нягтлан бодогчдын эрх олгох сургалтад хамрагдсан нийт нягтлан бодогчдод Ёс зүйн, мэргэжлийн үнэ цэнэ сэдвээр 3 өдрийн 18 цагийн хичээл, хууль эрх зүйн сургалтын 5 өдрийн 30 цагийн хичээлийн хөтөлбөрт компанийн тухай хуулийг тусгайлан оруулан зохион байгуулж байна.
- Мэргэшсэн нягтлан бодогчдын эрх сунгах сургалтад Компанийн тухай хууль болон компанийн нийгмийн хариуцлага, ил тод байдал сэдвээр 6 цагийн
- Аудиторуудыг бэлтгэх сургалтад Компанийн тухай хууль болон компанийн нийгмийн хариуцлага, ил тод байдал, Дотоод аудит, дотоод хяналтын чиглэлээр 8 цагийн хичээлийн хөтөлбөрт тусган орж байна.

Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд “Хадгаламж зээлийн хоршооны зарчмууд ба засаглал, гишүүдийн оролцоо” сэдэвт сургалтыг Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний хороо, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвтэй хамтран Улаанбаатар хотод 10, орон нутагт 16 удаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 2-р улиралд 9 удаагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 46 хадгаламж зээлийн хоршооны 195 сонгуульт ажилтан, ажилтнууд хамрагдсан байна. 2014 онд зохион байгуулах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран зохион байгуулах "2014 онд олон нийтэд болон зохицуулалтын байгууллагуудад зориулсан сургалт, сурталчилгааны төлөвлөгөө"-г боловсруулж, Ажлын албаны даргын 2014 оны 57 тоот тушаалаар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу банк бус санхүүгийн байгууллагуудын удирдах ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос 6 дугаар сарын 14-нд зохион байгуулсан удирдах арга барил манлайллын сургалтад нийт 31 банк бус санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэх удирдлага оролцсон. Хорооноос шинээр тусгай зөвшөөрөл авсан банзк бус санхүүгийн байгууллагуудын удирдах ажилтнуудад зориулан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам зааврын талаар” сургалтыг 7 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийт 75 банк бу санхүүгийн байгууллагын удирдах ажилтнууд оролцсон. Банк бус санхүүгийн байгууллагуудыг удирдлагын мэдээллийн системээр хангах чиглэлээр гүйцэтгэгч компани болон Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулаад байна.

Монголын хөрөнгийн биржээс Монголын “Компанийн засаглалын кодекс”-ийг дагаж мөрдөх талаар одоогийн “А” самбарт бүртгэлтэй компаниудад албан бичгээр мэдэгдэл хүргүүлж, мөрдөж ажиллах шаардлага тавин ажиллаж байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газраас компанийн тухай хуулийн дагуу хувьцаат компаниуд, тэдгээрийн удирдлагуудад тавигдаж буй шаардлагууд, хийж гүйцэтгэх ёстой ажил, үүргийн талаар анхааруулга мэдээллийг хүргүүллээ. Үүнд:

Хорооны 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 5/383 тоот албан бичгээр бүх хувьцаат компаниудад санхүүгийн тайлангийн жил дууссанаар хувьцаа эзэмшигчдэдээ зориулан үйл ажиллагааны санхүүгийн үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, санхүүгийн тайлагналын ажиллагааг нарийвчлан зохицуулсан харилцааны талаарх мэдээлэл, сануулгыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хорооны 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 5/483 тоот, 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 5/2503 тоот албан бичгээр хувьцаат компаниуд нь хувьцаа эзэмшигчдэд зориулан хагас, бүтэн жилийн байдлаар үйл ажиллагааны тайлангаа өөрийн компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулж байх шаардлагатай талаарх сануулгыг хүргүүлж, Монголын хөрөнгийн биржийн зүгээс дээрх чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болголоо.

Энэ оны 12 дугаар сард төрийн өмчит компаниудын Аудитын хороо, хараат бус гишүүдийн оролцоо, тайлан боловсруулалт, санхүүгийн тунгалаг байдал, хариуцлагын

тогтолцоо, нэр дэвшүүлэх хороо, бие даасан байдал, үйл ажиллагааны журмын тухай, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын тогтмол ажиллагаа, эрх бүхий албан тушаалтны эрх зүйн мэдлэг олгох, төлөөлөн удирдах зөвлөл, дэд хороодын хурал, хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангах, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах, компанийн нээлттэй ил тод байдлыг төлөвшүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос 2014 оны 6 дугаар сарын 7-8-ны өдөр Эрдэнэт хотод “Компанийн засаглал ба түүний ач холбогдол” нэртэй семинарыг Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран зохион байгууллаа. Уг семинарт Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит компани, хувийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагууд болон хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудаас бүрдсэн нийт 35 хүн хамрагдсан байна. Дээрх үйл ажиллагаа нь орон нутагт анх удаа компанийн засаглалын чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа байсан бөгөөд ийм төрлийн арга хэмжээг шат дараатайгаар зохион байгуулж байх хүсэлтийг оролцогчдын зүгээс гаргаж байв.

Дундговь аймагт болсон “Говийн бүсийн ажил олгогч нарын зөвлөгөөн”-д оролцогч Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага, үйлдвэрчний эвлэлийн холбоодын дарга нарын нийт 63 хүнд “Компанийн засаглалын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн болно. Тус зөвлөгөөнд оролцогч нараас уг илтгэлийг сонсоод компанийн засаглалын асуудал чухал бөгөөд зөвлөгөөний шинэлэг мэдээлэлтэй, сонин сэдэв болж байгааг дурьдаад аймгууд дээрээ жич сургалт мэдээлэл авах хүсэлтийг гаргасан. Тухайлбал, Дорноговь аймаг эргэж холбогдож аймагтаа компанийн засаглалын сургалтыг 2015 оны эхээр авах, Өмнөговь аймаг 2015 оны 3-р сарын орчимд авахаар харилцан тохиролцож ажиллаж байна.

Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн хүрээнд уг бодлогын баримт бичгийн төслийг хэлэлцэн эцэслэн боловсруулаад төр болон төрийн бус байгууллага, яамд, иргэдийн хүрээнд хэлэлцүүлэх ажлыг Эдийн засгийн хөгжлийн яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг-Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Одоогоор бодлогын баримт бичгийн эхний хэлэлцүүлгийг төрийн байгууллагуудын хүрээнд 1, “Компанийн нийгмийн хариуцлагын Үндэсний форум 2014”-д оролцогч байгууллагуудын дунд 1 хэлэлцүүлэг өрнүүлж, протоколыг нэгтгэж хүргүүлээд байна. Цаашид холбогдох яамд төрийн байгууллага болон мэргэжлийн байгууллагуудын хүрээнд 3 удаагийн хэлэлцүүлгийг хийхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд энэ нь яамдын бүтэц бүрэлдэхүүнтэй өөрчлөгдөж байгаагаар холбогдон түр хойшлогдоод байгаа болно.

Бодлого боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Герман улсын компанийн нийгмийн хариуцлагын бодлого түүний хэрэгжилттэй танилцах, ажлын хэсгийн боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийг танилцуулж холбогдох мэргэжлийн хүмүүсээс зөвлөмж зөвлөгөө авах зорилгоор ажлын хэсгийн 9 гишүүний бүрэлдэхүүн оролцсон туршлага солилцох, танилцах уулзалтыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа. Германы нийгмийн

хариуцлагын стратеги нь хэрэглэгчдийн эрх ашиг тэдгээрийн сонирхлыг хамгаалах, компанийн засаглалыг ил тод нээлттэй хэрэгжүүлэх, ажилчдын тэгш эрх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах түүнийг бий болгоход тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжих үндсэн зорилтуудаас бүрдэж тус зорилтуудын хүрээнд жилийн дундаж үнэлгээний компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах, Компанийн нийгмийн хариуцлагыг таниулах, илтгэл үнэмшлийг бий болгох, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, боловсрол, судалгааны салбарт компанийн нийгмийн хариуцлагыг түлхүү оруулах, олон улсын түвшинд компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах болон хөгжлийн бодлогыг тодорхойлох /Европын холбоо, Итали улстай туршлага хуваалцах, судлах зэрэг үйл ажиллагаа хийгдсэн, нийгэм рүү чиглэсэн компанийн нийгмийн хариуцлагын уулзалт, семинарыг хөхүүлэн дэмжих, Компанийн нийгмийн хариуцлагыг -байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжлийг дэмжих гэсэн үндсэн 6 зүйлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны нийт ажилтнуудад Холбооны бүгд найрамдах Герман улсын нийгмийн хариуцлагын сайн туршлагын талаар илтгэл танилцуулга хийж тавьсан байна.

Компанийн нийгмийн хариуцлагын стандарт ISO 26000-г сурталчлан таниулах сургалтын модулийг МАОЭНХолбоо орчуулан бэлтгээд байна. Уг сургалтын модульд Нийгмийн хариуцлагын талаар бүх ойлголтууд багтсан бөгөөд цаашид Монгол улсын засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг хэсэг болгон боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэн, аж ахуй нэг байгууллагад сургалт зохион байгуулах бэлтгэл бүрэн хангагдаад байна.

Отгон тэнгэр их сургуулийн Бизнесийн тэнхимийн багш, Шинжлэх ухаан техникийн их сургуулийн докторант Б.Довуучтай хамтран “Ногдол ашгийн бодлого” сэдэвт илтгэл, хэлэлцүүлгийг Үнэт цаасны газар болон бусад холбогдох газар, хэлтсүүдээс мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулж энэхүү уулзалтаас тодорхой саналуудыг гарсан бөгөөд ялангуяа хувьцаат компанийн ногдол ашгийн бодлогын заавар гаргах шаардлагатай болохыг тодорхойлон энэ чиглэлээр дээрх илтгэгчтэй хамтран ажиллахаар санал гарган дахин 1 удаагийн хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны ажилтнуудын хүрээнд хийсэн.

УБИС-ийн багш, судлаач Х.Сэлэнгэ “Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагыг үнэлэх арга зүйн зарим асуудал” сэдвээр докторын зэрэг горилсон судалгааны ажлыг хэлэлцүүлэх ажил 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж санхүүгийн зохицуулах хорооны мэргэжлийн газар мэргэжилтэн, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Компанийн засаглалын хөтөлбөр хэрэгжүүлэх албанаас оролцож, санал зөвлөмж, шүүмж өгч ажиллалаа. Энэхүү ажил нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх тулгамдсан асуудлын нэг болох хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах ялангуяа компанийн засаглалыг үр ашгийг нэмэгдүүлэх үндэслэл болох өмчийн эзэн, төлөөлөгчийн хоорондын үр ашигт харилцаа ба түүнийг бий болгоход гүйцэтгэх удирдлагыг хэрхэн үнэлж байгаагаар тодорхойлогдох талаар хөндсөн цаг үеэ олсон чухал сэдэв байлаа.

Судалгааны ажил компанийн засаглал, гүйцэтгэлийн үнэлгээний онолын үзэл баримтлал, загваруудыг судлах; нээлттэй компанийн засаглалын асуудлыг суурь судалгааны үр дүнд тулгуурлан шинжлэх; Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индексийг бүрдүүлэгч хувьцаат компаниудын гүйцэтгэх удирдлагыг үнэлэх өнөөгийн байдлыг судлах; гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглах боломжит арга загварыг дэвшүүлэх 4 зорилтыг дэвшүүлсэн байна.

Тайлант онд Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилт дэмжлэг туслалцааны дор компанийн засаглалтай холбогдох хууль, дүрэм журмын эмхтгэлийг боловсруулж Адмон ХХК-нд хэвлүүлж мэргэжлийн байгууллага, хувьцаат компани, төрийн өмчит компаниуд болон даатгалын компаниудад хүргүүлэн ажиллалаа. Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2013 оны санхүү эдийн засгийн үзүүлэлт болон нийгмийн хариуцлагын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэн товхимол болгон гаргасан.